



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-21-51

2020 04.07 № 9/681
танай 2020.04.19-ны № 03/525 -Т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан “Орон нутгийн түвшин дэх мэдээлэл харилцааны ажлуудыг үргэлжлүүлэх” арга хэмжээг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлж байна.

Хавсралт хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Ц.ЧОГСОМЖАВ

БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОЛБОРЛОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц. ЧОГСОМЖАВ

**ХЭНТИЙ АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа	Зардлын эх үүсвэр /мян.төг/	Хариуцах эзэн	Хамтрах талууд
1	Судалгаа, мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд				
1.1	Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох газруудад хүргүүлэх, төлөвлөгөөний дагуух хэрэгжилтийн тайланг гаргуулах, нэгтгэн дүгнэх	2, 4 дүгээр улирал	-	ХОХБТХ	Дэд зөвлөлийн гишүүн байгууллагууд
1.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргаж дэд зөвлөлийн гишүүд, холбогдох сумдад хүргүүлэх	Улирал бүр	-	ХОХБТХ	АМГТГ, Ажлын алба
1.3	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг гаргаж баталгаажуулан ОУИТБС-ын ажлын албанд цахимаар болон бичгээр хүргүүлэх	1 дүгээр улиралд	-	СТСХ	ХОХБТХ, Татварын хэлтэс, сумдын ЗДТГ
1.4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, өөрчлөлт, тайлан, зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээ тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх, холбогдох газартай хамтран хяналт тавьж ажиллах	2, 4 дүгээр улиралд	-	Сумдын ЗДТГ, БОАЖГ	СТСХ, МХГ
1.5	Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах	2, 4 дүгээр улиралд	-	БОАЖГ	Сумдын ЗДТГ
1.6	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аймаг, сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээ, гэрээний хэрэгжилтийг ОУИТБС болон холбогдох байгууллагад хүргүүлэх	2, 4 дүгээр улиралд	-	ХОХБТХ	Сумдын ЗДТГ

1.7	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтын ажил зохион байгуулах	3 дугаар улиралд	БХНСЗ 1500,0	АЗДТГ	МХГ, ЦГ, БОАЖГ, ОБГ, ХХҮГ, ТХ, СГЗ, ГИХГ, Сумдын ЗДТГ
2	Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд				
2.1	Аймгийн http://khentii.gov.mn цахим хуудсанд ОУИТБС цэсийг нэмж, ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн мэдээллийн санг байршуулах, тэдгээрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг олон нийтэд нээлттэй сурталчлах	Улирал бүр	-	АЗДТГ	БОАЖГ, Сумдын ЗДТГ
2.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зарласан ажлын байр, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээтэй холбоотой мэдээллийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулах	Жилийн турш	-	ХОХБТХ	ХХҮГ, Сумдын ЗДТГ, ААН-үүд
2.3	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагааны тайлан, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй арга хэмжээ, ажил үйлчилгээг тухайн орон нутгийн багийн иргэдийн нийтийн хурал, сумын ИТХ-д хэлэлцүүлж, олон нийтэд нээлттэй ил тод тайлагнах ажлыг хэвшүүлэх	Жилийн турш	-	Сумын ЗДТГ	Багийн Засаг дарга нар, ААН-үүд
2.4	Хөдөө сумдын иргэдийг мэдээллээр хангах зорилгоор эрх зүйн цахим хөтөч http://e-khutuch.mn/ сайт болон “Хэнтийн мэдээ” сониноор дамжуулан хууль, эрх зүйн буланг ажиллуулах	Жилийн турш	-	ХЭЗХ	ХОХБТХ, БОАЖГ, Сумдын ЗДТГ
3	Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд				
3.1	Аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах, уул уурхайн чиглэлийн сургалт, зөвлөгөөнд дэд зөвлөлийн гишүүд, иргэний нийгмийн төлөөллийг хамруулах	Тухай бүр	-	Аймгийн дэд зөвлөл	Холбогдох байгууллагууд
3.2	Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр албан уулзалт зохион байгуулах	2, 4 дүгээр улиралд	-	Аймгийн дэд зөвлөл	Салбарын төрийн байгууллагууд
3.3	Төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зөвлөгөөн зохион байгуулах	Жилдээ	2000,0	Аймгийн дэд зөвлөл	Холбогдох байгууллагууд

АЙМГИЙН ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛ